



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/109/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: М.Айнур Утас: 94159291 Цахим хаяг: ainurmarkh@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	17
3.1 Ерөнхий зүйл.....	17
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	18
3.4 Материаллаг байдал	18
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	18
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	20
3.8 Аудитын гол асуудал	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
4. Аудитын илрүүлэлт	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

ЦЭНГЭЛ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Б.ЕРБОЛАТ ТАНАА

2022.02.25 № 204
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын ЗДТГ-ын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Цэнгэл сумын ЗДТГ-Дүгнэлт

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Цэнгэл сумын ЗДТГ-Дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,023,621.00</u>	<u>45,828,201.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31130	Нэмэлт санхүүжилт	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31212	Монгол банкин дахь харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	-
33	АВЛАГА	1,386,286.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,386,286.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	-
33400	Зээлийн хүүгийн авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	6,637,335.00	3,073,401.00
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал	-	-
35130	Эм боох материал	-	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
354	Хангамжийн материал	4,887,335.00	3,073,401.00
35410	Бичиг хэргийн материал	-	-
35420	Аж ахуйн материал	-	-
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	4,887,335.00	3,073,401.00
35500	Биологийн хөрөнгө	-	-
35600	Мал амьтад	1,750,000.00	-
36	НӨӨЦИЙН БАРАА	-	42,754,800.00
36100	Барааны нөөц	-	-
36200	Үрийн нөөц	-	-
36300	Тэжээлийн нөөц	-	42,754,800.00
36400	Шатахууны нөөц	-	-
36500	Буудайн нөөц	-	-
36600	Бусад нөөц	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,867,649,105.80</u>	<u>4,253,290,515.63</u>

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,867,649,105.80	4,253,290,515.63
391	Газар	91,402,000.00	91,402,000.00
392	Биет хөрөнгө	4,776,247,105.80	4,161,888,515.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,154,049,782.00	2,178,049,782.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(549,151,949.68)	(696,311,418.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	188,691,496.00	161,855,696.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(159,838,651.00)	(140,630,467.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,519,117,673.00	3,709,291,517.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,255,096,260.04)	(1,915,425,640.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,913,259.00	26,913,259.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,826,329.17)	(15,949,450.17)
39209	Зам, гүүрийн байгууламж	999,601,727.00	1,003,407,927.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(150,755,121.35)	(191,542,942.79)
39211	Баглан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	-	-
39212	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	243,268,952.00	263,570,076.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(219,268,951.96)	(221,339,822.76)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	541,480.00	-
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	2,018,400.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,018,400.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	-
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,875,672,726.80</u>	<u>4,299,118,716.63</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	-
41350	Зээлийн хүүгийн өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,875,672,726.80</u>	<u>4,299,118,716.63</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,875,672,726.80	4,299,118,716.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	450,580,962.00	450,580,962.00
51101	Өмч: - төрийн	450,580,962.00	450,580,962.00
51102	- хувийн	-	-
51103	- хувьцаат	-	-
51104	Халаасны хувьцаа	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	3,951,835,099.71	3,375,281,089.54
51210	Өмнөх үеийн үр дүн	3,951,835,099.71	3,951,835,099.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	(576,554,010.17)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	473,256,665.09	473,256,665.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,875,672,726.80</u>	<u>4,299,118,716.63</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	694,976,892.00	868,265,449.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	40,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	40,000,000.00
120001	Хувьцааны ногдол ашиг	-	-
120002	Хүүгийн орлого	-	-
120003	Торгуулийн орлого	-	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	40,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	40,000,000.00
120005	Түрээсийн орлого	-	-
120006	Газрын тосны орлого	-	-
120007	Навигацийн орлого	-	-
120008	Монгол банкны ашиг	-	-
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	694,976,892.00	828,265,449.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	232,125,000.00	276,817,368.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	-
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	232,125,000.00	276,817,368.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,169,792.00	7,217,181.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,000,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,169,792.00	2,217,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
131106	Төсвийн урамшуулал	-	-

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	455,682,100.00	544,230,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	455,682,100.00	544,230,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-	-
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	-
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	-
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,144,512,938.49	1,426,233,534.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,144,512,938.49	1,426,233,534.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,083,591,214.49	1,405,009,588.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,707,024.00	274,327,055.00
210101	Үндсэн цалин	180,626,517.00	198,855,728.00
210102	Нэмэгдэл	48,966,955.00	62,176,050.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	-	-
210105	Гэрээт ажлын хөлс	20,113,552.00	13,295,277.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,916,900.00	39,448,800.00
210201	Тэтгэврийн даатгал	25,274,900.00	27,760,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,660,500.00	2,922,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,128,400.00	2,337,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	532,100.00	584,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,321,000.00	5,844,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,777,381.00	25,924,637.00
210301	Гэрэл, цахилгаан	1,447,688.00	1,687,537.00
210302	Түлш, халаалт	24,196,898.00	23,237,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,132,795.00	1,000,000.00
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	26,804,300.00	26,772,457.00
210401	Бичиг хэрэг	1,938,000.00	1,984,750.00
210402	Тээвэр, шатахуун	22,355,300.00	17,988,673.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,511,000.00	2,370,600.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал актисны зардал	-	4,428,434.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	-
2105	Нормативт зардал	273,800.00	364,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	273,800.00	364,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,546,240.00	835,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	4,546,240.00	835,300.00
2107	Томилолт, зочны зардал	6,813,230.00	4,740,700.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	6,813,230.00	4,740,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,556,100.00	1,028,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,200.00	94,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,900.00	181,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	50,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,500.00	288,180.00
210807	Газрын төлбөр	45,600.00	21,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	731,196,239.49	1,031,567,859.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,771,557.00	141,262,306.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	476,520.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	686,874,682.49	889,829,033.69
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,921,724.00	21,223,946.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,115,800.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	-
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,115,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	48,805,924.00	21,223,946.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,805,924.00	21,223,946.00
213404	Хөрөнгийн	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
224001	Стратегийн нөөц хөрөнгө	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(449,536,046.49)	(557,968,085.69)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	18,585,924.48
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	18,585,924.48
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	-
225003	Хөрөнгө оруулалтын гарз	-	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
225006	Гадаадын төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдүүлэх	-	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	-
225008	Дотоод эх үүсвэрээс олгосон зээл	-	-
225009	Дамжуулан зээлдүүлэх зээл	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(18,585,924.48)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(449,536,046.49)	(576,554,010.17)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	450,580,962.00	473,256,665.09	4,399,994,235.20	5,323,831,862.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,580,962.00	473,256,665.09	4,399,994,235.20	5,323,831,862.29
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			-448,159,135.49	-448,159,135.49
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,580,962.00	473,256,665.09	3,951,835,099.71	4,875,672,726.80
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	450,580,962.00	473,256,665.09	3,951,835,099.71	4,875,672,726.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,580,962.00	473,256,665.09	3,951,835,099.71	4,875,672,726.80
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00

Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-576,554,010.07	-576,554,010.07
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,580,962.00	473,256,665.09	3,375,281,089.64	4,299,118,716.73

2.4 Мөнгөн гүйлгээний тайлан

				/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	462,851,892.00	551,448,081.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-	
120	Нийтлэг татварын бус орлого	-	-	
120001	Хувьцааны ногдол ашиг			
120002	Хүүгийн орлого			
120003	Торгуулийн орлого			
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих			
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих			
120005	Түрээсийн орлого			
120006	Газрын тосны орлого			
120007	Навигацийн орлого			
120008	Монгол банкны ашиг			
120009	Бусад орлого			
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	462,851,892.00	551,448,081.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт			
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт			
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг			
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх			
131005	Хөрөнгийн санхүүжилт			
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих			
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих			
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих			
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,169,792.00	7,217,181.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,000,000.00	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл			
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,169,792.00	2,217,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	455,682,100.00	544,230,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	455,682,100.00	544,230,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/		
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	459,038,892.00	534,209,081.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	459,038,892.00	534,209,081.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,117,168.00	512,985,135.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,617,925.00	271,010,519.00
210101	Үндсэн цалин	180,537,418.00	196,267,719.00
210102	Нэмэгдэл	48,966,955.00	61,611,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	20,113,552.00	13,131,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,916,900.00	39,448,800.00
210201	Тэтгэврийн даатгал	25,274,900.00	27,760,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,660,500.00	2,922,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,128,400.00	2,337,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	532,100.00	584,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,321,000.00	5,844,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,658,781.00	25,409,637.00
210301	Гэрэл, цахилгаан	1,414,183.00	1,172,537.00
210302	Түлш, халаалт	25,078,298.00	23,237,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,166,300.00	1,000,000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	26,098,400.00	17,504,743.00
210401	Бичиг хэрэг	1,938,000.00	1,661,800.00
210402	Тээвэр, шатахуун	21,649,400.00	13,694,443.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,511,000.00	2,060,500.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		88,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	458,300.00	421,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	458,300.00	421,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,370,740.00	1,100,000.00

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	4,370,740.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,813,230.00	4,740,700.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	6,813,230.00	4,740,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,556,100.00	1,040,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,200.00	94,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,900.00	181,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	50,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,500.00	299,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	21,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,626,792.00	152,308,636.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,076,792.00	151,808,636.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,921,724.00	21,223,946.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,115,800.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,115,800.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	48,805,924.00	21,223,946.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага		
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,805,924.00	21,223,946.00
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,813,000.00</u>	<u>17,239,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,813,000.00	17,239,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,813,000.00	17,239,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,813,000.00	17,239,000.00
220001	Барилга байгууламж		

221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,813,000.00	17,239,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,813,000.00)</u>	<u>(17,239,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	543,358,400.00	523,006,954.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	543,358,400.00	523,006,954.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,358,400.00	523,006,954.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,340,400.00	271,010,519.00
210101	Үндсэн цалин	206,887,200.00	196,267,719.00
210102	Нэмэгдэл	62,321,800.00	61,611,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	13,131,400.00	13,131,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,448,800.00	39,448,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,760,300.00	27,760,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,922,100.00	2,922,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,337,700.00	2,337,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	584,400.00	584,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,844,300.00	5,844,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,409,700.00	25,409,637.00
210301	Гэрэл, цахилгаан	1,172,600.00	1,172,537.00
210302	Түлш, халаалт	23,237,100.00	23,237,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	16,526,200.00	16,526,200.00
210401	Бичиг хэрэг	1,661,800.00	1,661,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,715,900.00	12,715,900.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	2,060,500.00	2,060,500.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	421,800.00	421,800.00

Цэнгэл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	421,800.00	421,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,740,700.00	4,740,700.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,740,700.00	4,740,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,040,300.00	1,040,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,000.00	94,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,900.00	181,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,700.00	50,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	299,700.00	299,700.00
210807	Газрын төлбөр	21,500.00	21,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	172,330,500.00	163,308,998.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	171,830,500.00	162,808,998.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	543,358,400.00	523,006,954.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	543,358,400.00	523,006,954.00
132001	Орон нутгийн төсвөөс	543,358,400.00	523,006,954.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00

610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	27.00
620001	Удирдах ажилтан	11.00	11.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	27.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7.00	9.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11.00	11.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,217,181.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7,217,181.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,217,181.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	978,543.00
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун		978,543.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,238,638.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,238,638.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,217,181.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,217,181.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,217,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		

IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 03/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийг удирдлагаар хангах, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэл бүхий орон нутгийн удирдах байгууллага юм.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь хүний нөөц, байгалийн баялаг, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцан бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болох зорилго тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1143.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 576.6 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1.3	-	-1.3
Урьдчилгаа			
Бараа материал	6.6	3.1	-3.5
Нөөцийн бараа	-	42.7	42.7
Үндсэн хөрөнгө	4867.6	4253.3	-614.3
Нийт хөрөнгө	4875.7	4299.1	-576.6
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4875.7	4299.1	-576.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4875.7	4299.1	-576.6

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эхэнд 1.3 сая төгрөгийн татвартай холбоотой авлага байсныг тайлант онд барагдуулан ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3.1 сая төгрөг болж оны эхнээс 3.5 сая төгрөгөөр буурсан оны эхний үлдэгдлээс зарцуулсан холбоотой байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 44.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, бусад эх үүсвэрээр 40.0 сая төгрөгийн тэжээлийн нөөц бэлтгэж, 41.7 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 3.7 сая төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл бусад хангамжийн материалын үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр, нөөцийн барааны үлдэгдэл 42.7 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 576.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 17.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, бусад эх үүсвэрээр 276.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсныг бүртгэлд тусган ажилласан байна. Нийт 58.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 76.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох газрын шийдвэрээр бүртгэлээс хассаны 56.3 сая төгрөгийг акталж, 20.3 сая төгрөгийг шилжүүлэн ажилласан байна. Үндсэн хөрөнгөд нийт 889.8 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэн борлон эцэст үлдэгдэлгүй байна. Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 576.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд - 576.6 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 164.5 сая төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн байна. Урсгал санхүүжилтийн орлого өмнөх оноос 88.5 сая төгрөгөөр буюу 19.4 хувиар өсөж, үнэ төлбөргүй авсан орлого, хөрөнгийн санхүүжилтийн орлого 75.9 сая төгрөгөөр буюу 32.7 хувиар өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 272.9 сая төгрөгөөр буюу 23.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын анхны төсвийг 445.3 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 543.4 сая төгрөг болгон өөрчилж анх баталсан төсвөөс 97.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 543.4 сая төгрөгийн төсөв баталснаас 421.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 121.9 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 544.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 523.0 сая төгрөгийг зарцуулж, үндсэн санхүүжилтээс 21.3 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Тайлант оны нийт санхүүжилтэд 0.8 сая төгрөгийг төрийн сангаас батлагдсан төсвөөс илүү олгож, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Тайлант оны нийт санхүүжилтээс төвлөрүүлсэн цэвэр дүн нь 20.3 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 523.0 сая төгрөг буюу 96.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвөөс 7.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авч, тээвэр шатахууны зардалд 0.9 сая төгрөгийг, бараа үйлчилгээний зардалд 6.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд 543.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж 523.0 сая төгрөг зарцуулсан байна. Үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай цалин, НДШ, халаалт зэрэг зардлуудыг хасаж тооцоход тэвчиж болох зардлын дүн 187.7 сая төгрөгийн 10 хувь 18.8 сая төгрөгийг хэмнэж ажиллагаас 9.8 сая төгрөгийг хэмнэж /цалингийн зардлаас бусад зардлын хэмнэлт/ төсөвт төвлөрүүлж, 8.9 сая төгрөгийн төсвийг хэмнэж, төсөвт төвлөрүүлээгүй байна. Үүнээс үзэхэд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 548.1 сая төгрөгийн 117 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 57.9 сая төгрөгийн 8 гүйлгээг байршуулсан эсэхийг шалгаж үзэхэд 43.4 сая төгрөгийн 6 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байсан зөрчил илэрсэн. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 86% хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдөж, хариуг хугацаанд ирүүлж, зөрчлийг давтан гаргаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гүйцэтгэлийн аудитаар үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 8.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байсанд албан шаардлага өгөгдөж, Шилэн дансанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 43.4 сая төгрөгийн 6 гүйлгээг байршуулаагүй байсан зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 14.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр 543.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 187.7 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувиар буюу 18.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллахаас 9.8 сая төгрөгийн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлж, 8.9 сая төгрөгийн урсгал зардлыг төсөвт төвлөрүүлээгүй, тогтоолын 1.4-т заасныг зөрчиж 5.5 сая мянган төгрөгийн албаны конторын тавилга худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах; Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1-ийн 1.1-д “*үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*”, 1.4-т “*энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх*” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах талаар албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 43.4 сая төгрөгийн 6 гүйлгээг байршуулаагүй байсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Цэнгэл сумын ЗДТГ							1	14.4	1	43.4